

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8
2.8.2 Авлага.....	8
2.8.3 Урьдчилгаа	10
2.8.4 Бараа материал	10
2.8.5 Үндсэн хөрөнгө	11
2.8.6 Өр төлбөр	12
2.8.7 Засгийн газрын хувь оролцоо.....	12
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	13
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	14
2.10. Шилэн дансны мэдээлэл	14
2.11. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.12. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3. Менежментийн захидал	16
3.1 худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал	16
3.2 худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал	16
3.3 харьяа газруудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал.....	17
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	18
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	18
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж, ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ЗГНС	Засгийн газрын нөөц сан



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

2020 Оч. 24 № 1437
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, НББОУС, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн холбогдох хууль журмыг мөрдөн ажиллах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 05-наас 2020 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж нар гүйцэтгэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн ХЭГ/868 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо мэргэшлийн өндөр түвшний, цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр Ерөнхий сайд, Танхимыг шуурхай хангах, Засгийн газрын тасралтгүй, хэвийн, үр ашигтай ажиллагааны зохистой орчин бүрдүүлэхэд оршино гэж тодорхойлсон ба эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Засгийн газрын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Ерөнхий сайд, Танхим, бүх шатны Хурал, Засаг даргыг орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, нутгийн удирдлагын чиглэлээр өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны үр нөлөөтэй, хэвийн жигд ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;
- Танхимын хуралдааны зохион байгуулалт, хүний нөөцийн болон захиргааны удирдлагын манлайллыг хангах, төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагчид санхүүгийн үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт, шалгалт, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үр дүнд өгөх үнэлгээний үр ашгийг дээшлүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Төрийн мэдээллийн сүлжээг хөгжүүлэх зохион байгуулалт, мэргэшил-арга зүйн удирдлагаар хангах;
- Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны талаар олон нийтийг нээлттэй, шуурхай мэдээллээр тогтмол хангах, олон нийттэй харилцах;
- Засгийн газраас явуулах шинэчлэлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүй, удирдлагын дэмжлэг үзүүлэх;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын үйл ажиллагааны болон төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагааг эрхлэн явуулах;
- Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдад бодлогын зөвлөгөө өгөх, бүх талын үйлчилгээ, дэмжлэгээр хангах.

Төсвийн ерөнхийлөн захирагч УСНББОУС, түүнд нийцүүлэн дараах хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Засгийн газрын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мэргэжлийн байгууллагаар холбогдох стандарт, хууль, журамд нийцүүлэн шинэчилсэн байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, энэ чиглэлээр дүгнэлт, зөвлөмж, мэргэшил, арга зүйгээр хангах, бүх талын дэмжлэг үзүүлэх, үр дүнг нэгтгэх, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг нэгтгэн үнэлж дүгнэх, харьяа төсвийн байгууллага, төрийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлдэг байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 76,853.6 сая төгрөгийн 1 хувь буюу 768.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 10,640.2 сая, эцсийн үлдэгдэл 8,218.1 сая төгрөг болж, 2,322.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Касст байгаа бэлэн мөнгө	239.5	293.5	54.0
Банканд байгаа бэлэн мөнгө	10,400.7	8,024.6	-2,376.1
Замд яваа мөнгөн хөрөнгө			0
Хадгаламж			0
Дүн	10,640.2	8,318.1	-2,322.1
Үүнээс, байгууллагын төрлөөр			0
Төсөвт байгууллага	4,089.2	1,189.8	-2,899.5
Төсөл/сан	222.1	771.1	549.0
Төрийн сан			0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	6,328.8	6,357.3	28.5
Дүн	10,640.2	8,318.1	-2,322.1

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 8,024.6 сая төгрөгөөс 720.4 сая төгрөг төсөвт байгууллагын, 95.6 сая төгрөг төсөл сангийн, 7,158.0 сая төгрөг төрийн өмчит байгууллагын, 50.6 сая төгрөг ахмадын сангийн үлдэгдэл байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, Ухаалаг засаг төслүүдийн санхүүгийн тайланг Сангийн сайдын багцад шилжүүлснээс 2,704.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг хассан байна.

Банканд байршиж буй 8,024.6 сая төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 4,257.4 сая төгрөг, мөн гадаад валютаарх кассын үлдэгдэл 2.7 сая төгрөг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайдын ажлын алба 1.0 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ 0.7 сая төгрөгийн И баримтгүй худалдан авалт хийсэн, нийгмийн даатгалын тайланд 6.6 сая төгрөгийг дутуу тайлагнасан, Нийслэл хотын албан татвар суутгаж авсан боловч тайлагнаагүй, анхан шатны баримтгүй 0.8 сая төгрөгийн гүйлгээ хийсэн;
- Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ 14.3 сая төгрөгийн зардлыг дутуу бүртгэж тайлагнасан;
- Удирдлагын академи УТҮГ 2 сарын түрээсийн орлого 0.7 сая төгрөгийг тооцож аваагүй;
- Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ 44.5 сая төгрөгийг татвараас хасагдах зардлыг илүү тооцож 4.4 сая төгрөгийн татварыг дутуу ногдуулсан байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 461.1 сая, эцсийн үлдэгдэл 893.1 сая төгрөг болж, 432.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.3	12.7	10.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	137.2	207.4	70.2
Татаас, санхүүжилтийн авлага	3.5	260.2	256.8
Дансны авлага /ТӨҮГ/	3.6	3.6	-
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.2	0.2	(0.0)
Бусад авлага	314.3	409.0	94.7
Дүн	461.1	893.0	431.9
Үүнээс, байгууллагын төрлөөр			0
Төсөвт байгууллага	363.8	768.5	404.7
Төсөл/сан			0.00
Төрийн сан			0
ТӨҮГ болон ОНӨҮГ	97.3	124.6	27.3
Дүн	461.1	893.0	432.0

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оноос шилжиж ирсэн дараах харьяа газруудын авлага байна. Үүнд:

- Монгол төрийн түүхийн музейн Сүхбаатар дүүргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэх гаргасан боловч шийдвэрлэгдээгүй “Оргил софт” ХХК-иас авах 6.2 сая төгрөг;
- Засгийн газрын авто бааз УТҮГ “Хьюндай Автомотив” ХХК-иас авах шүүхийн шатанд байгаа түрээсийн авлага 176.3 сая төгрөг;
- Засгийн газрын авто бааз УТҮГ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас авах хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршиж байгаа 400 автомашины гаржийн барилгын үлдэгдэл санхүүжилтээс үүссэн, гүйцэтгэгч байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргаснаас шалтгаалан үлдэгдэлтэй байгаа 181.3 сая төгрөг;

Тайлант онд үүссэн дараах авлагууд байна. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн дансанд БНХАУ-ын Засгийн газраас санхүүжүүлсэн Ерөнхий сайдын ажлын албаны хандивын орлогыг оны эцэст татан төвлөрүүлснээс үүссэн 192.2 сая төгрөг;
- ЗГНС-гаас санхүүжүүлсэн МОНЦАМЭ агентлаг, Хязгааргүй дурлал ТББ-аас авах Сангийн яамтай хоорондын тооцоогоор үүсгэсэн 62.2 сая төгрөг;
- Компьютер, тоног төхөөрөмж нийлэх гэрээний дагуу хөрөнгө оруулалтын санхүүжилтийг оны эцэст банкны баталгааг үндэслэн гүйцэтгэгчид шилжүүлсэн Ай-Ти-Зон ХХК-иас авах 91.9 сая төгрөг, Эм-Ай технологи ХХК-иас авах 49.4 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа газруудад авлагын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ 3.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Засгийн газрын авто бааз УТҮГ тээврийн үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой үүссэн 6 харилцагчийн 11.8 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Удирдлагын академи УТҮГ-ын олон жилийн насжилттай авлага барагдаагүй;
- Монгол төрийн түүхийн музей нь Оргилсофт ХХК-иас музейн техник, тоног төхөөрөмжөө дутуу нийлүүлсэн авлагыг барагдуулаагүй байна.

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 70.3 сая, эцсийн үлдэгдэл 352.1 сая төгрөг болж, 281.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Төсөвт байгууллага	9.2	35.1	25.9
Урьдчилж гарсан зардал	51.1	308.9	257.8
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.9	0	-1.9
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		0	0
Томилолтын урьдчилгаа	8.1	8.1	0
Дүн	70.3	352.1	281.8
Үүнээс, байгууллагын төрлөөр			0
Төсөвт байгууллага	70.3	352.1	281.8
Төсөл/сан			0
Төрийн сан			0
ТӨҮГ болон ОНӨҮГ			0
Дүн	70.3	352.1	281.8

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд тайлант онд үүссэн 281.7 сая **төгрөгийн** бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. **Үүнд:**

- ЗГХЭГ-ын хөрөнгө оруулалтаар худалдан авсан 899.2 сая төгрөгийн дансны үнэтэй 5 суудлын авто машиныг Засгийн газрын авто бааз УТҮГ нь тайлант онд тооцоо нийлсэн актаар хүлээн авсан боловч ТӨБЗГ-ын тогтоол шийдвэр гараагүйн улмаас бүртгэлд аваагүй боловч автомашинтай холбоотой урсгал зардалд 190.1 сая төгрөгийг зарцуулсан;
- ЗГХЭГ он дамнаж хэвлэл захиалга, программ хангамжийн төлбөр, бараа ажил үйлчилгээний бусад зардалд урьдчилж шилжүүлсэн 115.4 сая төгрөг;
- Монгол Төрийн түүхийн музей соёл дурсгалын үзмэрийн даатгалын төлбөрт урьдчилж шилжүүлсэн 8.2 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 2,485.5 сая, эцсийн үлдэгдэл 2,614.9 сая төгрөг болж, 129.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Бэлэн бүтээгдэхүүн	83.1	33.8	-49.3
Хангамжийн материал	2,359.0	2,537.6	178.6
Биологийн хөрөнгө	43.4	43.5	0.1
Дүн	2,485.5	2,614.9	129.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			0
Төсөвт байгууллага	1,616.1	1,670.9	54.8
Төсөл/сан			0.0
Төрийн сан			0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	869.4	944.0	74.6
Дүн	2,485.5	2,614.9	129.4

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тайланд хугацаанд 5,108.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 4,987.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Мөн холбогдох тушаал, шийдвэрүүдийн дагуу 58.4 сая төгрөгийн бараа материалыг балансаас балансад шилжүүлсэн, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжүүлж авсан байгууллагуудын бараа материал 10.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, шилжсэн төсөл хөтөлбөрийн нэгжийн 20.1 сая төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ ашиглалтад тавьж олгон, зарцуулсан 1.3 сая төгрөгийн бараа материалыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 75,409.9 сая, эцсийн үлдэгдэл 79,761.4 сая төгрөг болж, 4,351.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Биет хөрөнгө	68,321.0	71,413.3	3,092.3
Барилга, байгууламж, орон сууц	48,864.4	49,860.1	995.7
Авто-тээврийн хэрэгсэл	9,628.5	10,871.3	1,242.7
Машин тоног төхөөрөмж	4,467.0	5,140.9	673.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,038.6	3,088.2	49.7
Дуусаагүй барилга, байгууламж	691.4	734.6	43.2
Бусад үндсэн хөрөнгө	1,444.0	1,474.4	30.4
Дуусаагүй барилга, байгууламж		50.4	50.4
Ном	187.1	193.4	6.3
Биет бус хөрөнгө	7,088.9	8,348.0	1,259.2
Программ хангамж	224.8	784.9	560.1
Бусад биет бус хөрөнгө	6,864.1	7,563.1	699.1
Дүн	75,409.9	79,761.3	4,351.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			0
Төсөвт байгууллага	55,648.6	58,720.7	3,072.1
Төсөл/сан			0
Төрийн сан			0
ТӨҮГ болон ОНӨҮГ	19,761.3	21,040.7	1,279.4
Дүн	75,409.9	79,761.4	4,351.5

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,922.7 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 1,032.5 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,926.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 315.2 сая, акталсан 331.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд тайлант онд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ -ын урсгал засвар 50.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа газруудад үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ данснаас хасагдсан үндсэн хөрөнгийн 8.1 сая төгрөгийн дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй, программ хангамжид элэгдэл тооцоогүйгээс 1.5 сая төгрөгийн элэгдэл дутуу тайлагнасан
- Засгийн газрын авто бааз УТҮГ нийт 5 автомашиныг 2019 оны 3 дугаар сар болон 6 дугаар сард Монгол Хьюндай автоматив ХХК, Таванбогд ХХК-иас хүлээж авч, ашиглаж байгаа боловч ЗГХЭГ-аас шийдвэр гараагүй тул балансад бүртгээгүй байна.

2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,392.2 сая, эцсийн үлдэгдэл 2,068.8 сая төгрөг болж, 323.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №.6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Ажилчидтай холбогдсон өглөг	0.1	0.0	-0.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг		62.2	62.2
Бусад өглөг	309.4	722.7	413.3
Урьдчилж орсон орлого	2,083.7	1,283.7	-800
Дүн	2,393.2	2,068.6	-323.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			0
Төсөвт байгууллага	96.5	93.4	3.0
Төсөл/сан	181.4	681.4	500.0
Төрийн сан			0
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,114.4	1,294.0	820.4
Дүн	2,392.2	2,068.7	323.4

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн үлдэгдэлд харьяа газруудын дараах өр төлбөрүүд бүртгэлтэй байна. Үүнд:

- Удирдлагын академи УТҮГ-ын сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого 1,167.7 сая төгрөг;
- Харьяа УТҮГ-уудын түрээсийн төлбөрийн урьдчилж орсон орлого 116.3 сая төгрөг;
- Тайлант онд хийгдээгүй хөрөнгө оруулалтын 2 ажлын санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулснаас үүссэн гүйцэтгэгчид өгөх өглөг 500.0 сая төгрөг;
- Засгийн газрын авто бааз Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас авах хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршиж байгаа 400 автомашины гаржийн барилгын үлдэгдэл санхүүжилтээс үүссэн, гүйцэтгэгч байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргаснаас шалтгаалан үлдэгдэлтэй байгаа 181.3 сая төгрөг

Аудитын илрүүлэлт: Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ нь Харуул хамгаалалтын албаны 12 дугаар сарын зардлын 10.2 сая төгрөгийг өглөг үүсгээгүй байна.

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 74,253.6 сая, эцсийн үлдэгдэл 73,754.5 сая төгрөг болж, 499.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	39,931.5	39,892.4	-39.1
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		757.6	757.6
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,166.0	3,166.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	4,082.2	2,870.8	-1,211.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,073.9	27,067.7	-6.2
Дүн	74,253.6	73,754.5	-499.1

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны нэмж төлөгдсөн капитал өмнөх оноос нэмэгдсэн нь Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-т хөрөнгө оруулалтаар хийгдсэн 11, 12-р байрны дээвэр, цахилгаан шатны урсгал засварыг капиталжуулахаар хуримтлуулан бүртгэснээс үүссэн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 61,903.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 23,189.2 сая төгрөгийг урсгал зардалд, 38,714.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 61,728.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 175.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 54,860.7 сая төгрөг олгож, туслах үйл ажиллагааны орлого 177.4 сая төгрөг төвлөрүүлж, нийт урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл 55,060.8 сая төгрөг буюу 88.9 хувьтай байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- Цалин, НДШ, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд нь Үндэсний брэндийн бодлогын зөвлөлийн ажлын алба Ерөнхий сайдын багцад шилжсэнтэй холбоотой бүтэц, орон тоо өөрчлөгдсөнөөс 2,202.9 сая төгрөгөөр;
- Хангамжийн материал эд хогшлын зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлснээс 176.6 сая төгрөгөөр;
- Гадаадын зочин төлөөлөгчийн айлчлал цуцлагдаж хойшилсонтой холбоотой 242.4 сая төгрөгөөр;
- Төсвийн жилд хэрэгжүүлээгүй барилга байгууламж, их засварын зардал 3,680.0 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 67 төсөл, арга хэмжээнд 38,714.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 35,034.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Ажил гүйцэтгэгч байгууллагад гүйцэтгэлээр 1,279.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 33,254.1 сая төгрөгийг харьяа байгууллагууд болон орон нутагт эрхийг шилжүүлсэн байна.

Мөн хийгдээгүй 2 ажлын 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Нэмэлт төсөв: Нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжаар 812.2 сая, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан 919.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 845.8 сая, нийт 2,577.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал зардалд 2,647.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

